

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГАД НЭР ДЭВШҮҮЛЭХ ТУХАЙ АСУУДЛААР  
НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 12 дугаар  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн А.Бакей**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал дахь Ардчилсан Намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогтыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргад улируулан ажиллуулахаар нэр дэвшүүлснийг тус Байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогтыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргад улируулан ажиллуулахыг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогт нь Ховд аймгийн Ховд хотын 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, ОХУ-ын Москва хотын Усны аж ахуйн дээд сургуулийг усны инженер мэргэжлээр, Санхүү эдийн засгийн дээд сургуулийг банк санхүүч, эдийн засагч мэргэжлээр тус тус төгссөн бөгөөд Гаалийн ерөнхий газрын Тамгын хэлтсийн байцаагч, мөн Орхон аймаг дахь Гаалийн газрын дарга, "Хайрхан холдинг" ХХК-ний захирал, Гаалийн ерөнхий газрын дэд дарга 2012-2013 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Нутгийн удирдлагын дэд хорооны дарга, 2013 оноос Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар сонгогдон ажиллаж ирсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлаар тус Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН А.БАКЕЙ**

